



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2020 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/79

Улаанбаатар хот

2020 оны эхний хагас жилийн үндсэн үйл
ажиллагааны давсан орлогыг зарцуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 74 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”, Удирдлагын зөвлөлийн гишүүдийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2020 оны эхний хагас жилийн үндсэн үйл ажиллагааны давсан орлого болох 12,880,570 /арван хоёр сая найман зуун наян мянга таван зуун дал/ төгрөгийг “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”, Удирдлагын зөвлөлийн гишүүдийн хурлаас гарсан шийдвэрийн дагуу хавсралтаар баталсан зардлуудад зарцуулсугай.

2. Үндсэн үйл ажиллагаанаас давсан орлого 12,880,570 /арван хоёр сая найман зуун наян мянга таван зуун дал/ төгрөгийг 100900020406 дугаартай нэмэлт санхүүжилтийн данснаас гарган, зарцуулахыг Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Ц.Хэрлэнцэцэг/-т зөвшөөрсүгэй.

3. Зарцуулалтыг журмын дагуу гарган Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэхийг Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Ц.Хэрлэнцэцэг/, Санхүүгийн дотоод хяналтын ажилтан /С.Чогсом/ нарт үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ:



Л.НАСАНЦЭНГЭЛ

000000568